



МОНГОЛ УЛСЫН
УУЛ УУРХАЙН САЙДЫН
ТУШААЛ

2014 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 83

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 52, 2012 оны 142 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Уул уурхайн сайдын шийдвэрээр олгогдох Монгол Улсын Засгийн газрын шагнал "Салбарын тэргүүний ажилтан хүндэт тэмдгээр шагнах журам"-ыг нэгдүгээр хавсралтаар, Уул уурхайн яамны шагнал "Жуух бичгээр шагнах журам"-ыг хоёрдугаар хавсралтаар, шагнуулах хүний тодорхойлолтын анкетын загварыг гуравдугаар, "Уул уурхайн салбарын түүхэн ой хүндэт медалиар шагнах журам"-ыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Энэ журам гарсантай холбогдуулж Уул уурхайн сайдын 2012 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 28 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



САЙД

68 0242

Уул уурхайн сайдын 2014 оны
04-р сарын 28-ны өдрийн
85 тоот тушаалын нэгдүгээр хавсралт

САЛБАРЫН ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН ХҮНДЭТ ТЭМДГЭЭР ШАГНАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 142 дугаар тогтоолыг үндэслэн геологи, уул уурхай, газрын тосны салбарыг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан, ажлын онцгой амжилт бүтээл гаргасан тэргүүний хүмүүсийг Уул уурхайн сайдын тушаалаар Монгол Улсын Засгийн газрын шагнал "Тэргүүний геологич", "Тэргүүний уурхайчин", "Газрын тосны тэргүүний ажилтан" хүндэт тэмдгээр шагнахад энэ журмыг мөрдөнө.

2. Салбарын тэргүүний ажилтан тэмдгээр дор дурдсан шалгуур үзүүлэлтийг хангасан хүмүүсийг шагнана. Үүнд:

а. Салбарын тэргүүний ажилтан тэмдгээр шагнуулах санаачилгыг өмчийн аливаа хэлбэрийг харгалзахгүйгээр, тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллага гаргаж болно. Шагналд нэр дэвшиж байгаа хүн нь геологи, уул уурхай, газрын тосны салбарт 12-оос доошгүй жил, тухайн байгууллагат 3-аас доошгүй жил тогтвор суурьшилтай ажилласан байна.

б. Уул уурхайн салбарын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, техник, тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангаж, өндөр үр ашигтай ажиллуулах, байгаль орчинд халгүй дэвшилтэт шинэ техник, технологи нэвтрүүлэх, экспортын хэмжээг нэмэгдүүлэх, зэрэгт мэргэжлийн ур чадвараа дайчлан идэвх санаачлагатай ажилласан удирдах болон инженер техникийн ажилтан, ажилчид ;

в. Ажлын амжилтаараа хамт олноо манлайлан ажиллаж, эрхэлсэн ажилдаа өндөр амжилт гарган үр бүтээлтэй ажиллаж байгаа ажилчид, албан хаагчид;

г. Салбарын мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэхэд бодитой хувь нэмэр оруулсан, эрдэм шинжилгээ судалгааны ажилд шинэ нээлт бүтээл гаргасан багш, эрдэмтэд;

д. Салбарыг хөгжүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан, төр, олон нийтийн байгууллагын зүтгэлтэн, ахмадууд, гадаадын иргэд ;

е. Салбарын үйл ажиллагаанд онцгой үр дүн өгөхүйц нээлт, шинэ бүтээл, санал санаачлага гаргасан, үйлдвэрлэлийн найдвартай ажиллагааг хангах, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой дэвшилтэт шинэ техник, технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлсэн, иргэд ;

ж. Үйлдвэрлэлд учирч болох ноцтой аваарь ослыг урьдчилан сэргийлж, таслан зогсоох арга хэмжээ авсан, ослын хохирол уршгийг арилгах ажилд онцгой үүрэг гүйцэтгэсэн ажилтан, ажилчдад тус тус олгож болно.

з. Сонгуульт болон нам олон нийтийн байгууллага нь гишүүд идэвхтнээ шагнуулах саналыг тухайн ажиллаж байсан үндсэн байгууллагад нь гаргана.

и. "Журам"-ын 2-ын д.е.ж хэсэгг заасан үзүүлэлтээр шагнагдах хүмүүст ажилласан жилийг хамааруулахгүй байж болно.

3.Салбарын тэргүүний ажилтан хүндэт тэмдгээр шагнагдагсдад хувийн дугаар бүхий үнэмлэх олгох ба тэмдэг, үнэмлэхний загварыг Уул уурхайн сайдын тушаалаар батална.

Хоёр. Шагналыг мэдүүлэх:

4. Шагнуулах хүний ажил байдлын тодорхойлолтыг тухайн хүний ажиллаж байгаа аж ахуйн нэгж, байгууллага гаргаж түүний шагнуулах үндэслэлийг тодорхой бичиж, ажлын үзүүлэлт, судалгаа тооцоогоор баталгаажуулан, нээлт бүтээлийн жагсаалтыг хуулбарлан хавсаргана. Уг тодорхойлолтыг хамт олны буюу удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж зөвшөөрсөн байна.

5. Аж ахуйн нэгж, байгууллага нь тодорхойлолтдоо нутаг дэвсгэрийн төрийн захиргааны байгууллагаас, хэрэв Уул уурхайн сайдын эрхлэх хүрээний бус салбарын байгууллагаас шагнуулах хүний хувьд өөрийн салбарын яамны санал авч, тухайн шагналыг олгох хугацаанаас 30 хоногийн өмнө яаманд ирүүлнэ. **Тухайн байгууллагын ҮЭ-ийн байгууллага болон бусад ТББ нь гишүүдээ салбарын шагналаар шагнуулах саналаа байгууллагын даргадаа тавьж шийдүүлнэ.**

6. Шагнуулах хүний материал дор дурьдсан зүйлээс бүрдэнэ. Үүнд:

а. Ажил байдлын тодорхойлолт, ажлын үзүүлэлт, судалгаа тооцооны хамт /батлагдсан зааврын дагуу/

б. Хамт олны буюу удирдлагын зөвлөлийн хурлын тэмдэглэл

в. Нутаг дэсгэрийн төрийн захиргааны байгууллага болон холбогдох яамны саналаас бүрдэнэ.

Гурав. Салбарын тэргүүний ажилтан тэмдэг олгох

7.Салбарын тэргүүний ажилтан тэмдгийг энэ журмын 2 дугаар зүйлд заасан нөхцлийг хангасан хүмүүст салбарын онцлогийг үндэслэн дараах чиглэлээр олгоно.

а/ Геологийн салбарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагад ажиллагсад болон энэ чиглэлээр төрийн бодлого боловсруулдаг, тэдгээрт үйлчилдэг төрийн албан хаагчдыг "Тэргүүний геологич", тэмдгээр ;

б/ Уул уурхай, түлшний салбарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагад ажиллагсад болон энэ чиглэлээр төрийн бодлого боловсруулдаг, тэдгээрт үйлчилдэг төрийн албан хаагчдыг "Тэргүүний уурхайчин" хүндэт тэмдгээр ;

в/Газрын тосны салбарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагад ажиллагсад болон энэ чиглэлээр төрийн бодлого боловсруулдаг, тэдгээрт үйлчилдэг төрийн албан хаагчдыг "Газрын тосны тэргүүний ажилтан" тэмдэг тэмдгээр ;

8.Салбарын тэргүүний ажилтан тэмдгээр Үндэсний их баяр наадам, салбарын едрүүдийг болон тус салбарын ажил үйлчилгээ эрхэлж байгаа байгууллагуудын 20-оос дээш жилийн, 10 жилийн давтамжтай тэгш ойг тохиолдуулан шагнах бөгөөд журмын 2-ын д.е.ж хэсэгт заасан үзүүлэлтийг үндэслэн шагнах тохиолдолд энэ хугацаа хамаарахгүй байж болно.

Дөрөв.Шагналын хэмжээ

9.Салбарын тэргүүний ажилтан тэмдгээр шагнагдагсдад үнэмлэх, тэмдгийг яамнаас олгох бөгөөд уг шагналыг дагалдах мөнгө /нэг зуун мянган төгрөг/-ийг шагнагдсан хүнийг ажиллуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагаас гаргана.

10."Салбарын тэргүүний ажилтан"-ы тэмдэг, үнэмлэхийг өөрийн буруу биш шалтгаанаар үрэгдүүлсэн буюу гэмтээсэн тохиолдолд тухайн шагнагдсан хүний ажиллаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын албан тодорхойлолт, өөрийнх нь өргөдлийг үндэслэн нэг удаа үнийг нь төлүүлж солих буюу нөхөн олгож болно.

оОо

Уул уурхайн сайдын 2014 оны
04-р сарын 28-ны өдрийн 83-тоот
тушаалын хоёдугаар хавсралт

УУЛ УУРХАЙН ЯАМНЫ "ЖУУХ БИЧИГ"-ЭЭР ШАГНАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Геологи, уул уурхай, газрын тосны салбарыг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан, ажлын онцгой амжилт бүтээл гаргасан тэргүүний хүмүүсийг Уул уурхайн сайдын тушаалаар уул уурхайн яамны "Жуух бичиг"-ээр шагнахад энэ журмыг мөрдөнө.
2. Уул уурхайн яамны "Жуух бичиг"- дор дурдсан шалгуур үзүүлэлтийг хангасан хүмүүсийг шагнана. Үүнд:
 - а. Уул уурхайн яамны "Жуух бичиг"-ээр шагнуулах санаачилгыг өмчийн аливаа хэлбэрийг харгалзахгүйгээр, тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллага гаргаж болно. Шагналд нэр дэвшиж байгаа хүн нь геологи, уул уурхай, газрын тосны салбарт **6-аас дээш жил ажилласан, тухайн байгууллагад 2-оос доошгүй жил тогтвор суурьшилтай ажилласан** байна.
 - б. Уул уурхайн салбарын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, техник, тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангаж, өндөр үр ашигтай ажиллуулах, байгаль орчинд халгүй дэвшилтэт шинэ техник, технологи нэвтрүүлэх, экспортын хэмжээг нэмэгдүүлэх, зэрэгт мэргэжлийн үр чадвараа дайчлан идэвх санаачлагатай ажилласан удирдах болон инженер техникийн ажилтан, ажилчид ;
 - в. Ажлын амжилтаараа хамт олноо манлайлан ажиллаж, эрхэлсэн ажилдаа өндөр амжилт гарган , үр бүтээлтэй ажиллаж байгаа ажилчид, албан хаагчид;
 - г. Салбарын мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэхэд бодитой хувь нэмэр оруулж, эрдэм шинжилгээ судалгааны ажилд шинэ нээлт бүтээл гаргасан багш, эрдэмтэд;
 - д. Салбарыг хөгжүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан, төр, олон нийтийн байгууллагын зүтгэлтэн, ахмадууд, гадаадын иргэд ;
 - е. Салбарын үйл ажиллагаанд онцгой үр дүн өгөхүйц нээлт, шинэ бүтээл, оновчтой санал гаргасан, үйлдвэрлэлийн найдвартай ажиллагааг хангах, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой дэвшилтэт шинэ техник, технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлсэн,иргэд ;
 - ж. Үйлдвэрлэлд учирч болох ноцтой аварга ослыг урьдчилан сэргийлж, таслан зогсоох арга хэмжээ авсан, ослын хохирол уршгийг арилгах ажилд онцгой үүрэг гүйцэтгэсэн ажилтан, ажилчдад тус тус олгож болно.
3. Сонгуульт болон нам олон нийтийн байгууллага нь гишүүд идэвхтнээ шагнуулах саналыг тухайн ажиллаж байсан үндсэн байгууллагад нь гаргана.
- и. "Журам"-ын 2-ын д,е,ж хэсэгт заасан үзүүлэлтээр шагнагдах хүмүүст ажилласан жилийг хамааруулахгүй байж болно.

3. Уул уурхайн яамны "Жуух бичиг"-т Уул уурхайн сайд гарын үсэг зурж тамга дарж батлаажуулна.

Хоёр. Шагналыг мэдүүлэ, олгох.

4. Шагнуулах хүний ажил байдлын тодорхойлолтыг тухайн хүний ажиллаж байгаа аж ахуйн нэгж, байгууллага гаргаж түүний шагнуулах үндэслэлийг тодорхой бичиж, ажлын үзүүлэлт, судалгаа тооцоогоор баталгаажуулан, нээлт бүтээлийн жагсаалтыг хуулбарлан хавсаргана. Уг тодорхойлолтыг хамт олны буюу удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж зөвшөөрсөн байна.

5. Аж ахуйн нэгж, байгууллага нь тодорхойлолтдоо нутаг дэвсгэрийн төрийн захиргааны байгууллагаас, хэрэв Уул уурхайн сайдын эрхлэх хүрээний бус салбарын байгууллагаас шагнуулах хүний материалд өөрийн салбарын яамны санал авч, тухайн шагналыг олгох хугацаанаас 30 хоногийн өмнө яаманд ирүүлнэ.

6. Шагнуулах хүний материал дор дурьдсан зүйлээс бүрдэнэ. Үүнд:

а. Ажил байдлын тодорхойлолт, ажлын үзүүлэлт, судалгаа тооцооны хамт /батлагдсан зааврын дагуу/

б. Хамт олны буюу удирдлагын зөвлөлийн хурлын тэмдэглэл

в. Байгууллагын албан тоот

7. Яамны "Жуух бичиг"-ээр Үндэсний их баяр наадам, салбарын өдрүүдийг болон тус салбарын ажил үйлчилгээ эрхэлж байгаа байгууллагуудын 20-оос дээш жилийн, 10 жилийн давтамжтай тэгш ойг тохиолдуулан шагнах бөгөөд журмын 2-ын д,е,ж хэсэгт заасан үзүүлэлтийг үндэслэн шагнах тохиолдолд энэ хугацаа хамаарахгүй байж болно.

8. Яамны "Жуух бичиг"-ийг яамнаас олгох бөгөөд уг шагналыг дагалдах мөнгөн шагналыг шагнагдсан хүнийг ажиллуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагаас гаргана.

Уул үрхэйн сайдын 2014 оны
04-р сарын 26 ны өдрийн 83 тоот
тушаалын гуравдугаар хэвсрэлт



САЛБАРЫН ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН ТЭМДГЭЭР ШАГНУУЛАХ ХҮНИЙ АНКЕТ

1. Овог _____ 2. Эцэг/эхийн/ нэр _____
3. Нэр _____ 4. Хүйс: _____
5. Төрсөн он, сар, өдөр _____ 6. Регистрийн дугаар _____
7. Боловсрол, мэргэжил: _____
8. _____ Үндсэн захиргаа: _____
9. Одоогийн харъяалал: _____
10. Ажилладаг салбар: _____
11. Ажиласан хугацаа: Нийт _____ жил, үүнээс тухайн салбарт _____ жил, тухайн хамт олны дотор _____ жил

12. Урьд болон одоо ажиллаж байгаа газар:

№	Ажлын газрын нэр	Хугацаа	Эрхэлсэн ажил

14. Урьд шагнагдаж байсан шагналууд:

№	Шагналын нэр	Шагнагдсан он

14. Шагнуулах үндэслэл: Үүнд: тухайн хүний гаргасан ажлын амжилт, санаачлага, түүний үр дүн, үйлдвэрлэлд нэвтрүүлсэн шинэ технологи, санал санаачлага, бүтээл туурвил зэргийг сүүлийн 3 жилээр тусгана. Хэрэв шаардлагатай гэж үзвэл ажлын үзүүлэлт, холбогдох тооцоог хавсаргана.

15. Хамт _____ олны санал: _____

16. Ямар _____ шагналаар шагнуулах _____

_____ байгууллагын даргын гарын үсэг

Уул уурхайн сайдын 2014 оны
04-р сарын 28-ны өдрийн 48 тоот
тушаалын дөрөвдүгээр хэвсрэлт



УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ТҮҮХЭН ОЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР ШАГНАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Уул уурхайн салбарын түүхэн ойг тохиолдуулан тухайн салбарт олон жил үр бүтээлтэй ажилласан болон онцгой амжилт гаргасан тэргүүний хүмүүсийг салбарын түүхэн ойн хүндэт медалиар шагнахад энэ журмыг мөрдөнө.

2. Салбарын түүхэн ойн хүндэт медалиар шагнахад дор дурдсан шалгуур үзүүлэлтийг үндэслэн хүмүүсийг шагнана.

а. Шагнуулах санаачилгыг өмчийн аливаа хэлбэрийг харгалзахгүйгээр, тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллага гаргаж болно.

б. Тухайн салбарыг хөгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулж, эрхэлсэн ажилдаа өндөр амжилт гарган идэвхи санаачлагатай ажиллаж байгаа ажилчид, албан хаагчид;

в. Салбарын мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх бодитой хувь нэмэр оруулсан, эрдэм шинжилгээ судалгааны ажилд шинэ нээлт бүтээл гаргасан багш, эрдэмтэд;

г. Салбарт олон ажилласан идэвх санаачилгатай, үр бүтээлтэй ажилласан ахмадууд;

3. Хүндэт медалиар шагнагдагсад хувийн дугаар бүхий үнэмлэх олгох ба медаль, үнэмлэхний загварыг Уул уурхайн сайдын тушаалаар баталж, үнэмлэх дээр сайд гарын үсэг зурж тамга дарна.

Хоёр. Шагналыг мэдүүлэх:

4. Шагнуулах хүний ажил байдлын тодорхойлолтыг тухайн хүний ажиллаж байгаа аж ахуйн нэгж, байгууллага гаргаж түүний шагнуулах үндэслэлийг тодорхой бичиж, байгууллагын даргын албан тоотын хамт яаманд ирүүлнэ.